



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 11 сарын 06 өдөр

Дугаар А/538

Чойбалсан

Г Татварын хуулийн хэрэгжилтийг
хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 60.1.10 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Татварын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 26.3, 26.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй татвар төлөгч хувь хүн, хуулийн этгээдийг газар зүйн мэдээллийн системд суурилсан газар, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн системийг хөгжүүлэх суурь судалгааны мэдээлэл цуглуулах, татвар төлөгчид татварын хууль тогтоомжийн талаар сурталчилгаа, зөвлөгөө өгөх, хяналт тавих замаар далд эдийн засгийг бууруулах, орон нутгийн төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор "Татвар төлөгчийн шинэчилсэн бүртгэл, тооллого"-ын ажлыг удирдамж боловсруулан зохион байгуулахыг Дорнод аймгийн татварын газар (С.Бямбарагчаа)-т үүрэг болгосугай.

2.Аймгийн хэмжээнд газрын бүртгэл, ногдлын мэдээллийн зөрүүг арилгах, шүүхийн маргааныг эцэслэн шийдвэрлүүлэх, өмчилсөн газрын татварын ногдлыг холбогдох мэдээллийн санд үүсгэхийг Дорнод аймгийн татварын газар (С.Бямбарагчаа), аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Х.Гүенбат), аймгийн Улсын бүртгэлийн газар (Д.Оюунбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

3.Аймаг, сумын төсөвт төвлөрүүлэх татварын өрийн үлдэгдлийг татварын хууль тогтоомжийн хүрээнд хураан барагдуулах, аймаг, сумын төсвийн татварын орлогыг нэмэгдүүлэх, татварын бааз суурийг өргөтгөх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулахыг аймгийн Татварын газар (С.Бямбарагчаа)-т үүрэг болгосугай.

4."Татвар төлөгчийн шинэчилсэн бүртгэл, тооллого"-ын ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд үр дүнтэй зохион байгуулж, тайланг удирдамжид заасан хугацаанд аймгийн Татварын газарт ирүүлэхийг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5.Энэхүү захирамжид заасан ажлыг зохион байгуулахад бүх төрлийн дэмжлэг үзүүлж ажиллахыг аймаг, сумын нутгийн захиргааны байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ЕЛ



پسینہ مصر
مصریوں کی طرف سے
پسینہ مصر (پسینہ مصر)

www.dhammadownload.com

723

$\frac{60}{\text{میل (نم)}}$ $\frac{66}{\text{میل (8)}}$ $\frac{70}{\text{میل}}$

طریقہٴ لہر، یسین لہر، نکل عقیقہ، لہر، یسین لہر، یسین لہر

[illegible][illegible][illegible][illegible]

